

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот**Монгол Улсын 2026 оны төсвийн тухай
хууль баталсантай холбогдуулан авах
арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/- т зөвшөөрсүгэй:

1/Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод тулгамдаад буй асуудлуудын санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор 275.0 тэрбум төгрөг хүртэлх нийслэлийн дотоод үнэт цаас гаргах асуудлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Засгийн газрын ерийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичигт нийцүүлэн шийдвэрлэх.

2.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/- т даалгасугай:

1/төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, политехник коллеж, насан туршийн боловсролын төвийн багш нарын, төрийн болон орон нутгийн өмчийн эмнэлгийн эмч, эрүүл мэндийн ажилтны, шинжлэх ухааны салбарын албан хаагч нарын үндсэн цалинг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд заасан хэмжээгээр нэмэгдүүлэх;

2/төрийн албаны ангилал, зэрэглэлийг шинэчлэн, түүнтэй уялдуулан төрийн албан хаагчийн цалин хөлс, нэмэгдлийн асуудлыг оновчтой тогтоох эрх зүйн орчныг сайжруулж, холбогдох хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;

3/төсвийн хөрөнгө оруулалтаар эхэлсэн боловч дуусаагүй, зогссон барилга байгууламж, төслүүдэд дүн шинжилгээ хийх, холбогдох арга хэмжээ авах саналыг 2026 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулах;

4/ерөнхий боловсролын 6-12 дугаар ангийн нийт сурагчдад үдийн хоол хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг судлан

холбогдох эрх зүйн орчныг сайжруулж, Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авах;

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Х.Ганхуяг/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг